

Сайн байцгаана уу? Дэлхийг хамарсан аюултай өвчин тархсан хүнд, хэцүү үеийг бид хамтдаа туулж байна. Энэ үед ажил амьдралын хувьд хүн бүрт, айл бүрт, ажил алба болгонд тодорхой хэмжээний саад бэрхшээл тулгарч байгаа. Тиймээс манай **SEMOSAN** товчооныхон бид өөрсдөндөө байгаа боломжийг ашиглан олон монголчуудад маань тулгараад байгаа цаг үеийн асуулдалд мэргэжлийн хүний зөвөлгөө тусламжийг авахыг зорисон юм. Ингээд өнөөдрийн манай ливийн зочноор Серсэй анд партнэрс өмгөөлөгчийн товчооний өмгөөлөгч **FEREC SERCE** уригдан оролцож цагаачийн асуудал болон ажлын гэрээтэй холбоотой асуудлаар манайхны сонирхсон асуултанд хариулж ярилцах юм.

Дашрамд хэлэхэд бидний хувьд зочинтой шууд ярилцлага хийж байгаа анхны нэвтрүүлэг болохоор алдаа оноотой асуудлууд гарах магадлалтай, өөрөөр хэлбэл туршлага муутай гэсэн үгээ. Тиймээс та бүхнийг ойлгож хүлээж авахыг хүсье. Асуултаа бид урьчилаад хүмүүсээс авсан байгаа. Нэмэлтээр одоо илгээж болно. Ууганаа маань асуултыг нэгтгээд өгөх байх.

- [Ажлын гэрээтэй хүмүүс ажилгүй болж, гэрээ нь сунгагдах болов уу? Дахиад өөр газар ажлын гэрээ хүсэж болох болвуу, гаднаас хүсэх үү дотроос хүсэх үү, цагаачийн газраас ямар нэгэн хөнгөлөлттэй шийдвэр гарах болов уу гэх мэтээр санаа нь их зовнож байна. Ажлын гэрээтэй хүмүүс яг одоо юуг илүү анхаарах ёстой вэ?](#)

Ажлын гэрээтэй хүмүүс нийт 4 жилийн дараа уртаар гэрээгээ сунгах эрхтэй болдог. Эхний 2 жилдээ нэг газраа тогтвортой ажиллаад сунгалтаа хийлгэсэн бол дараагийн 2 жилдээ ажлын газраа анхны салбар дотроо цагаачид хүсэлт явуулахгүйгээр солиж болно. Хэрэв салбараа солих болвол эхний ажилласан жилүүд тооцогдохгүйгээр шинээр жил нь тоологдож эхлэнэ. Энэ нь ямар үр дагавартай вэ гэхээр нийт 4 жил ажиллаад уртаа хүсэх боломжтой байсан бол салбараа солисноос болоод эхний жилүүд тооцогдохгүй болно гэсэн үг.

Өнөөгийн нөхцөл байдалтай уялдаад та ажлаас халагдсан бол 3 сарын дотор өөр ажил хайж олоод ажиллах боломжтой байгаа. Мөн гол анхаарах зүйл бол 13 000 кроны цалингийн доод хэмжээг алдахгүй байх нь чухал. Таны хэдэн цаг ажиллахыг тооцохгүй зөвхөн орлогын хэмжээ 13 000аас доош байж болохгүй гэсэн шаардлага тавьж байгаа. Ажил олгогч нарт улсаас тусламж өгч байгаа. Улсаас цалингийн зөрүү буюу ойролцоогоор 60 хувийг улс өгч 40 хувийг ажил олгогч өгч байгаа тэхээр ажилтан дор хаяад 92%аа ажилласан цагаас үл хамааран авна гэсэн үг. Мөн та ажлаас халагдсан тохиололд хууль ёсны авах ёстой бүх тэтгэмжээ авах, шаардах эрхтэй. Энэ асуудлаар бидэнд хандаж зөвөлгөө аваарай. Цаг алдахгүй байх нь чухал байна.

- Ажлаас халагдаж байгаа иргэдэд нэг удаагийн ямар төрлийн тэтгэмжүүд байдаг вэ? Жишээ нь *omställningstöd* яаж хэрэгждэг вэ?

Одоогийн нөхцөл байдлаас болоод ажлаас шууд халагдсан тохиолдолд таны ажлын ямар төрлийн гэрээтэй болон ажилласан жилээс хамаарч 0-2 жил ажилласан бол 1 сарын хугацааны цалингаа авах цаашлаад 6 сар хүртэл хугацааны цалин авах боломжтой. Мөн амралтын 25 хоног болон нийт цугласан хоногоороо бодогдож мөнгөө авдаг. Байгууллага дампуурсан гэсэн тайлбартай тохиололд ч та мөнгөө авах эрхтэй шүү.

- Дублины гэрээний талаар, европын холбооны өөр оронд визтэй байж байгаад харалсан хүмүүс шведэд ажлын гэрээнд орохын тулд цагаачид ороход дублинээр буцаах эрсдэлтэй юу? Дублины асуудалтай хүмүүс хэдий хугацааны дараа цагаач хүсвэл буцаагдахгүй байж болох вэ? Хэдэн удаа хүсэж болох вэ? Европын өөр оронд визтэй байж байгаад харалсан хүн хэдэн жил болоод Шведэд цагаачлах эрх үүсэх вэ?

Дублины гэрээний дагуу нэг Европын холбооны оронд цагаач хүсээд дахин өөр газар цагаачлал хүсвэл эхний хүссэн орондоо буцаагдах мөн тэндээ асуудлаа дуусгах ёстой болдог. Шенгэний виз гаргасан орон нь цагаачлалын асуудлыг

хүлээн авах ёстой учраас тухайн орон руу шилжүүлэх хүсэлт явуулдаг. Цагаачийн алба таныг тухайн оронруу буцааж чадахгүй байх хуулийн хэд хэдэн нөхцөл байдаг. Үүнд тухайн орон хүлээж авахгүй гэх, тухайн оронд дайн байлдааны хүнд хэцүү нөхцөлтэй байх гэх мэт. Гэхдээ доорхи 2 төрлийн хугацаанд цагаач хүсвэл мөн буцаагдахгүй байх боломжтой.

1. Визээр орж ирээд хугацаа нь дууссанаас хойш 6 сарын дараа цагаачид ороход Дублин хамаарахгүй байх
 2. Цагаачлал хүсэж ороод шийдвэр гарснаас хойш 18 сарын дараа дахин цагаачлал хүссэн тохиолдолд Дублинээр буцаагдахгүй байх
- Хурууны хээ хэр удаан хадгалагддаг вэ?

Хурууны хээ алга болохгүйгээр GURODAC мэдээллийн санд хадгалаастай байдаг.

- Цагаачид хэрэг нь дуусаагүй байх хугацаандаа 4 сар татвар төлөөд ажилласан хүмүүс ажлын гэрээгээ хурдан хийхийн тулд шууд хэргээ хаалгаж болохуу? Жишээ нь *nöjdförklaring*, Ямар нэгэн сул эсвэл давуу тал үүнд бий юу?

Хамгийн анхны татгалзсан хариугаа заавал авах ёстой. Тэрний дараа ажлын гэрээ хүсэхэд шаардалагатай бүх нөхцөлөө хангасан бол хэргээ хаалгах хүсэлт явуулаад ажлын гэрээний хүсэлтээ 14 хоногтоо явуулах боломжтой

- Ажлын гэрээтэй байх хугацаандаа эцэг эхийн мөнгө *föräldrapenning* авсан бол ажлын гэрээний сунгалтанд асуудал тулгарах уу?

Шведийн нийгийн даатгалын газраас эцэг эхийн мөнгө авахыг зөвшөөрч шийдвэр гаргасан бол хуулийн дагуу ажлын гэрээнд нөлөөлөх ёсгүй. Гэхдээ ажил хийх гэрээтэй ирсэн гэдэг утгаараа зөвшөөрлөө сунгуулахад хүндрэл учирч болзошгүй.

- Хүүхэдтэй гэр бүлүүдийн хувьд ямар давуу тал байж болох вэ? Жишээ нь хэдэн жилийн өмнө хүүхдийн дасан зохицсон гэдгээр зөвшөөрөл өгсөн тохиолдол байсан. Өөрөөр оршин суух авах ямар боломжууд байдаг вэ? Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айлд харгалзаж үзэх заалтууд

бий юу? Шведэд төрөөд 8 жил болсон хүүхэдтэй айл цагаачилбал оршин суух авах боломжтой юу?

Хүүхэд дасан зохицсон гэдгээр Шведэд оршин суух авах маш ховор тохиолдол. Гэхдээ саяхан 3 долоо хоногийн өмнө над дээр өмгөөлөл нь явж байсан гэр бүл энэ шалтгаанаар авсан тохиолдол байгаа. Ялангуяа Швед улс хүүхдийн конвенцэд 2019 оноос нэгдсэн орсонтой холбоотой хүүхдийн рэх ашгийг нилээд нарийн авч үзэх боломжтой болоод байгаа. Жишээ нь энд төрөөд эндээ олон жил амьдарсан 11-ээс дээш настай шилжилтийн насандаа байгаа гэх мэт

- Ямар ямар нөхцөлөөр Шведэд цагаачлал хүсэх боломжтой байдаг вэ?

Шведэд цагаачлалын асуудлаар улс төрийн, шашны мөн бэлгийн өөр чиг хандлагатай болон тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг улсад нь хүлээн зөвшөөрдөггүй гадуурхагддаг гэсэн шалтгаануудаар маш нарийн бөгөөд хатуу шалгууртайгаар оршин суух эрх олгох боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл улс орны нөхцөл байдлаас маш их шалтгаална. Монголчуудын хувьд энэ асуудлаар улс орны зүгээс ямар нэгэн асуудал байдаггүй, улсаасаа хангалттай хэмжээний тусламж авах боломжтой гэж үздэг учраас татгалзах хариу авдаг. Хэрэв монголын талаас ямар нэгэн тусламж авах боломжгүйгээ бодитоогоор баталж чадвал авах боломжтой.

Цагаачлаад татгалзах хариу авсан хүмүүс швед улсаас гарах шийдвэр авсанаас хойш 4 жилийн дараа дахин цагаачлах эрх үүсдэг. Энэ хугацаандаа шийдвэрийг биелүүлэх боломжгүй шинэ нөхцөл байдал үүссэн гэдгээр 4 жил хүлээлгүй дахин хандах боломж байдаг.

Мөн хараар амьдардаг хүмүүст өөрийн зүгээс нэг боломж байдгийг хэлье.

Европын холбооны өөр ямар нэгэн улсад оршин суух эрхтэй Шведэд ажиллаж амьдардаг хүнтэй гэр бүлийн холбоо тогтоовол энэ үндэслэлээрээ та бүрэн цагаарах боломжтой.

- Бичиг баримтгүй иргэд ажлын байрны дарамтад их өртдөг. Цалингаа авч чадахгүй байх эсвэл олон цагаар ажиллах, амралтгүй ажиллах зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөрчсөн асуудлуудаар шүүхэд хандах

боломж байдаг уу? Цагийн бүртгэлийн дэвтэр эсвэл татвар төлсөн баримт гэх мэт бага зэрэг баримттай тохиолдолд. Тийм тохиолдол танд бий юу?

Хараар ажиллана гэдэг нь өөрөө хууль бус үйлдэл юм л да ажил олгогчийн зүгээс ч мөн адил. Тийм учраас хэрэв та өөрийгөө ажилласан гэдгийн баталж чадвал ажилласан цагийнхаа мөнгийг олж авах боломжтой. Ийм хэргүүд ихэвчлэн өмгөөлөгчөөр дамжуулан тухайн ажил олгогчид хандаж шаардлага хүргүүлснээр шийдэгдэх боломжтой байдаг.

- Хар тамга дарна гэсэн асуудал байдаг. Яг ямар тохиолдолд хар тамга дарагддаг вэ хэдэн жилээр дарагдаж болох вэ? Хар тамгатай хүмүүс ажлын гэрээний хүсэлт гаргаж болхуу? Гаргасан тохиолдолд хар тамганы хугацааг яаж тооцох вэ?

Хар тамга нь та цагаачийн албатай хамтарч ажиллаагүй, хилийн дүрэм болон хууль зөрчсөн тохиолдолд буцаж орож ирэхийг нь тодорхой хугацаагаар хориглосон хориг тавигдсан гэсэн үг юм. Хоригийг цагаачийн албаны шийдвэрээс харах боломжтой. Хориг тоологдох хугацаа нь 2 янз буюу хилээр гарснаас хойш тоологдох эсвэл шийдвэр гарснаас хойш тоологдох гэсэнв 1-4 жилийн хугацаанд тавигдаж болно.

- Шведэд ажлаад буцаж байгаа иргэд татварын албанаас ямар ямар буцаалтууд авч болох вэ? Жишээ нь тэтгэвэр юмуу оршуулгын гэх мэт

Татварын албанаас тухайн жилийн татварын буцаалтыг авах боломжтой. Өөр ямар нэгэн буцаалт байхгүй

- Шведэд харалсан хүн өөр хүнтэй нийлж бизнес эрхлээд түүгээрээ оршин суух авах боломжтой юу?

Ресторан нээлээ гээд оршин суух өгөхгүй. Харин хөрөнгө оруулалтын чиглэлээр цагаачийн албаны шаардлагыг хангасан тохиолдолд өөрийн орноос хүсэлт гаргах боломжтой. Мөн швед англи төгс хэлтэй, хангалттай хэмжээний хөрөнгөтэй, тухайн салбартаа мэргэжлийн туршлагатай байхыг шаарддаг. Хэрэв энэ чиглэлээр визтэй байгаад 2 жилийн турш амжилттай өсөн дэвшиж байгаа тохиолдолд байнгын оршин суухаа шууд хүсэх боломжтой.

- Хар тамгатай хүн гэрлэлтээр ирэхийн тулд заавал хугацаагаа дуустал нь хүлээх шаардлагатай юу?

Тэгэх шаардлагагүй. Гэр бүлийн шугамаар оршин суух гэж байдаг. Үүний дагуу хүнтэй гэрлэлтээ батлуулаад ирэхэд хар тамга орох гарах эрхийн хорио бүгд цуцлагдана.

- Татварын хуудсаа бөгөлөхөд ажлын гэрээтэй иргэд ямар ямар зүйл дээр онцгойлон анхаарах вэ? Жишээ нь замын зардал тооцуулах, шүүхийн болон өмгөөлөгчийн төлбөрийг бөглөх боломжтой гэсэн байна

Замын зардлаа тооцуулаад авах мөн ажилтай холбоотой гарсан шүүхийн болон өмгөөлөгчийн зардлыг бөглөөд тооцуулан авах боломжтой. Мөн гэрийн даатгалаас өмгөөлөгчийн задлаа авах боломж байдаг.

- Эцэг эх нь хүүхдээ дагаад оршин суух эрх авч болох уу?

Ганцаараа ирсэн хүүхэд гэдэг үндэслэлээр Швед улсын халамжийн дор 18 нас хүртлээ байх боломжтой. Энэ хугацаанд эцэг эх нь хүүхдээ дагах боломжгүй. Харин хүүхэд нь дүрвэн зугтсан гэсэн үндэслэлтэй бол хэсэг хугацааны дараа гэр бүл хамт байх эрхтэй гэсэн заалтын дагуу эцэг эх нь хүүхдээ дагаад цагаачид орох боломжтой.

Өнөөдөр бидэнтэй хамт байсан бүх хүмүүст баярлалаа. Бидний урилгыг хүлээн авч ажлынхаа хажуугаар монголчуудад маань зөвөлгөө өгсөн Феречдээ баярлалаа.

Манай СЭМОСАН товчоо үйл ажиллагаагаа цаашид идэвхтэй явуулж аль болох олон хүний асуудалд өөрсдийнхөө боломжоор туслахыг хичээж байгаа. Өнөөдрийн яригдсан асуултуудыг бид бичгээр ФБ дээрээ тавих болно. Та бүхэн хүссэн үедээ бидэнтэй холбогдож санаа оноогоо илэрхийлээрэй.

www.mongolsweden.eu